

- Асуулт:** Тамирчин уусан эм, тариулсан тарианыхаа хариуцлагыг өөрөө бүрэн хүлээнэ.
Хариулт: Үнэн. **Тайлбар:** Бүх тамирчид энэ асуудалд туйлын анхааралтай хандах хэрэгтэй. Өөрийн спортын замналдаа аз турших хэрэггүй. Хэрэв танд асуулт байвал- АСУУ! Хэрэв та хэрэглэх гэж байгаа бодисын найрлага, зориулалтыг мэдэхгүй, түүнийг хэрэглэж болох эсэхдээ 100 % итгэлгүй байвал- ТҮҮНИЙГ БҮҮ ХЭРЭГЛЭ!
- Асуулт:** Зөвхөн олимпийн эсвэл паралимпийн наадамд оролцох тамирчид л допингийн шинжилгээ өгөх үүрэгтэй. **Хариулт:** Худал. **Тайлбар:** Олон улс орон, олон улсын спортын холбоод өөрийн допингийн эсрэг хөтөлбөртэй байдаг. Энэ нь хэрэв та шигшээ багт багтан тэмцээнд оролцдог л бол тэмцээний үед ба тэмцээний бус үед гэртээ эсвэл бэлтгэл дээрээ шинжилгээнд хамрагдах боломжтой гэсэн үг юм.
- Асуулт:** ДДЭА гэж юу вэ? Дэлхийн Допингийн Эсрэг Алба, Дэлхийн Допингийн Эсрэг Агентлаг?
Хариулт: Дэлхийн Допингийн Эсрэг Агентлаг **Тайлбар:** Дэлхийн Допингийн Эсрэг Агентлагын зорилго нь спортын бүх төрөлд, бүх хэлбэрээр олон улсын түвшинд допингийн эсрэг тэмцлийн үйл ажиллагааг дэмжих, зохицуулах, хянахад оршино.
- Асуулт:** Тамирчин тэмцээний үед допингийн шинжилгээ өгөх тухай мэдэгдэл хүлээн авсан бол өөрийн төлөөний хүнийг гэрчээр дагуулан шинжилгээний өрөөнд очихыг зөвшөөрнө? **Хариулт:** Үнэн
Тайлбар: Тамирчин өөрийн төлөөний хүнийг сонгон шинжилгээний өрөөнд дагуулан очиж болно. Төлөөний хүн нь дасгалжуулагч, эмчийн аль нэг байна. Төлөөний хүн нь шинжилгээний шээхээс бусад бүх үе шатыг хянах эрхтэй. Шаардлагатай бол орчуулагчаа дагуулж болно.
- Асуулт:** Хэрэв ямар нэгэн эмийг тухайн улсад хэрэглэхийг зөвшөөрдөг бол, тамирчин гадаадаас худалдаж авсан ижил төрлийн эмийг айлтгүй хэрэглэж болно? **Хариулт:** Худал.
Тайлбар: Өөр өөр орнуудад худалдагдаж байгаа зарим эмүүд ижил нэртэй ч найрлага нь ялгаатай байж болно. Зарим тохиолдолд тэдгээр нь хориотой бодис агуулах нь бий. Хэрэв та худалдан авсан эмэндээ итгэлгүй байгаа бол хэрэглэхээсээ өмнө найрлагыг нь сайтар шалгаж, эмчээсээ зөвлөгөө аваарай.
- Асуулт :** Тамирчин жилд хамгийн дээд тал нь хэдэн удаа допингийн шинжилгээ өгөх вэ?
Хариулт: Хязгааргүй. **Тайлбар:** Жилд өгөх шинжилгээний тоонд ямар нэг хязгаар байхгүй. Тамирчин жилд тэмцээний болон тэмцээний бус үед түүвэр сонголтоор эсвэл зайлшгүй тохиолдолоор хэдэн ч удаа шинжилгээ өгч болно.
- Асуулт:** Шээсийг допингийн хяналтын зорилгоор шаардлагатай төхөөрөмжтэй дурын лабораторид шинжлүүлж болно? **Хариулт:** Худал. **Тайлбар:** Зөвхөн зохих өндөр шаардлагыг хангаж, Дэлхийн Допингийн Эсрэг Агентлагын магадлан итгэмжлэх авсан лаборатори л шээсийг допингийн хяналтын зорилгоор шинжлэх эрхтэй.
- Асуулт:** Хэрэв ямар нэг хүнсний нэмэлт тэжээлийг эмийн сангаас худалдан авсан бол түүнийг спортод шууд хэрэглэхийг зөвшөөрнө. **Хариулт:** Худал. **Тайлбар:** Ямар нэг тэжээл, бодисууд өөрийн гэсэн эрсдэл дагуулдаг. Маш олон хүнсний нэмэлт тэжээлүүд хориглосон бодис агуулсан байдаг. Учир нь олон орны үйлдвэрүүдийн хувьд бүтээгдэхүүний найрлагыг тамирчнаас чандлан нуух нь чухал гэж үздэг.
МЭРГЭН ЗӨВЛӨГӨӨ: Хэрэв үүнийг хэрэглэх нь маш сайн гэсэн яриа байвал- тэр нь хориглосон бодисыг агуулсан байж болзошгүй. Иймд өөрийн улсын хүнсний хөтөлбөрөөр баталгаажсан бүтээгдэхүүн хэрэглэж байхыг танд зөвлөө
- Асуулт:** Хөгжлийн бэрхшээлтэй тамирчин өөрт шаардлагатай эмээ чөлөөтэй хэрэглэж болно? **Хариулт:** Худал. **Тайлбар:** Хөгжлийн бэрхшээлтэй тамирчин ч хориотой бодисын жагсаалтыг адилхан дагаж мөрдөнө. Тамирчин өөрийн өвчний онцлогоос шалтгаалан тусгай эм хэрэглэх тохиолдолд Олон Улсын

All rights reserved 2007 WADA

Паралимпийн Хорооны эмнэлгийн комисс, эсвэл Үндэсний Допингийн Эсрэг байгууллагад Эмчилгээний Зорилгоор Чөлөөлүүлэх хүсэлт гаргах шаардлагатай. Тэдний хэрэглэж буй эмэнд автоматаар баталгаа олгохгүй.

10. **Асуулт:** Тамирчин хэн нэгний шээсийг ашиглан допингийн шинжилгээний дүн сөрөг гарахаас зайлсхийх нь маш хялбар зүйл? **Хариулт:** Худал. **Тайлбар:** Хэрэв та стандартын дагуу шинжилгээнд орж байгаа бол мэдэгдэл хүлээн авахаас шинжилгээ өгч дуусах хүртлэх бүх үйл ажиллагаа хяналтанд байна. Таныг допингийн хяналтын ажилтан шууд хянах учир шээсийг солих ямар нэг үйлдэл хийх нь маш хэцүү.
11. **Асуулт:** Би өвчин туссан үедээ эдгэхийн тулд шаардлагатай эмийг чөлөөтэй хэрэглэж болно? **Хариулт:** Худал. **Тайлбар:** Хэрэв та ханиад шуухинаа хүрсэн, халуурсан бол ямар нэг эмийг найрлагадаа хориглосон бодис агуулж байгаа эсэхийг нягтлалгүйгээр **БҮҮ** хэрэглэ. Хэрэглэх эмээ багийн эмчтэйгээ заавал зөвлө. Шинжилгээ сөрөг гарна гэдэг допинг хэрэглэсэн гэсэн үг болохыг санаж яваарай.
12. **Асуулт:** Тамирчных нь шинжилгээ сөрөг гарсан тохиолдолд түүнд хориотой бодис хэрэглэхэд тусалсан, зоригжуулсан, ятгасан дасгалжуулагч эсвэл багийн эмчид тамирчны нэг адил шийтгэл онооно? **Хариулт:** Үнэн. **Тайлбар:** Хориотой бодис, арга хэрэглэхэд нь тамирчинд туслах, зоригжуулах, ятгах нь допингийн эсрэг дүрмийн зөрчлийн нэг юм. Иймд тусалсан хүнийг Дэлхийн Допингийн Эсрэг Дүрмийн дагуу шийтгэнэ.
13. **Асуулт:** Допингийн хяналтын ажилтан нь шинжилгээ авахаар ирэх хугацаагаа тамирчинд заавал мэдэгдэх үүрэгтэй? **Хариулт:** Худал. **Тайлбар:** Допингийн хяналтын ажилтан нь төлөвлөгдсөн шинжилгээг урьдчилан зарлалгүйгээр авах эрхтэй. Допингийн хяналтын ажилтан нь шинжилгээг дурын хугацаанд, дурын газар авч болно. Харин Допингийн хяналтын ажилтан нь онцын шаардлагагүй зүйлээр тамирчны тухыг алдуулж болохгүй.
14. **Асуулт:** Дээжийг авч битүүмжлэн, шинжилгээний хуудас бөглөж дууссаны дараа түүнийг дахин онгойлгох, бохирдуулах, хэн нэг нь хөндлөнгөөс солихыг оролдох боломжгүй? **Хариулт:** Үнэн. **Тайлбар:** Тамирчин нэгэнт битүүмжлэгдсэн дээжийг хэн нэгэн хөндлөнгийн этгээд солих боломжгүй гэдэгт итгэлтэй байж болно. Нэмж хэлэхэд, хэрэв дээжний битүүмжлэлд сэжиг илэрвэл лаборатори түүнийг заавал мэдээлэх үүрэгтэй байдаг.
15. **Асуулт:** Хэрэв тамирчин завгүй байвал допингийн шинжилгээ өгөхөөс татгалзаж болно? **Хариулт:** Худал. **Тайлбар:** Допингийн шинжилгээ өгөхөөс татгалзвал шинжилгээний хариу сөрөг гарсантай ижил шийтгэл хүлээдэг. Хэрэв тамирчин мэдэгдэл хүлээн авсан хирнээ шинжилгээнд орохоос татгалзвал уг шалтгаанаа мэдэгдэх хуудсан дээр заавал тэмдэглүүлж, өөрийн дасгалжуулагч, эмчдээ мэдэгдэх үүрэгтэй.
16. **Асуулт:** Миний дасгалжуулагч намайг дагалдаж, допингийн шинжилгээний өрөөнд ирж болно? **Хариулт:** Үнэн. **Тайлбар:** Тамирчин бүр өөрийн төлөөний хүнийг гэрчээр дагуулж, допингийн шинжилгээний байранд ирэх эрхтэй.
17. **Асуулт:** Тамирчин өөрийнхөө сонгосон шээсний саванд дээжээ өгөх шаардлагатай. Хэрэв тамирчны сонгосон сав эвдэрсэн, эсвэл тамирчин сонгосон саваа бохир байна гэж бодож байсан чТэр өөр шинэ сав хүсэх эрхгүй? **Хариулт:** Худал. **Тайлбар:** Та битүүмжлэлтэй савнаас сонгож, дээжээ өгөх эрхтэй. Хэрэв та сонгосон савандаа итгэлгүй, сэтгэл хангалуун бус байвал дахин өөр сав хүссэн нь дээр. Өөр сав сонгох эрх танд бий.
18. **Асуулт:** Тамирчин допингийн шинжилгээнд орж болзошгүй учир хориотой бодис агуулсан эмийг хэрэглэхгүй гэдгээ эмчдээ хэлж болно. **Хариулт:** Үнэн. **Тайлбар:** Таны эмч эмийн найрлага дахь бодис хориотой бодисын жагсаалтанд ордог эсэхийг мэдэж байх нь маш чухал. Та хориотой бодис бүхий эм

"Please be advised that this information is subject to change at anytime. Always check with your International Federation or National Federation for the most up-to-date anti-doping regulations."

UPDATED January 2009

All rights reserved 2007 WADA

хэрэглэхээсээ өмнө Олон улсын болон Үндэсний холбоо, эсвэл допингийн эсрэг байгууллагаараа дамжуулан эмчилгээний зорилгоор чөлөөлүүлэх хүсэлт гаргах хэрэгтэй. Яаралтай тохиолдолд хэрэглэх журмыг ч таны эмч мэдэж байх ёстой.

19. **Асуулт:** Та хангалттай хэмжээгээр шээж чадаагүй тохиолдолд дутуу шээсэн дээрээ нэмж цусны шинжилгээ өгөхийг хүсэх эрхтэй? **Хариулт:**Худал. **Тайлбар:** Хэрэв та эхний удаа хангалттай хэмжээгээр шээж чадаагүй бол таны шээсийг түр битүүмжлэх ба та хэмжээг гүйцээх хүртлээ дахин шээх шаардлагатай.
20. **Асуулт:** Зарим тохиолдолд би хориотой бодис хэрэглэн шударга бусаар ялалт авч болно? **Хариулт:** Худал. **Тайлбар:** Та хэдий бүх хүчээ дайчлан өрсөлдсөн ч, хориотой бодис хэрэглэсэн тул энэ нь жинхэнэ ялалт биш. Энэ нь таныг спорт дахь шударга өрсөлдөөний зарчим, өөрийгөө, өрсөлдөгчөө үл хүндэтгэдэг болохыг харуулж буй хэрэг юм.
21. **Асуулт:** Та найрлаганд нь юу орсныг байгаа мэдэхгүй байсан ч, өөрийнхөө итгэлтэй хүнээс авсан бол уг эмийг шууд хэрэглэж болно? **Хариулт:** Худал. **Тайлбар:** Тамирчин өөрийнхөө биед оруулж буй эмийн бодис юу болохыг үргэлж мэдэж байх шаардлагатай. Найрлагыг нь мэдэхгүй, сохроор хэрэглэсэн эм таныг допингийн шалгалтанд унагаад зогсохгүй эрүүл мэндэд тань аюул учруулж болохыг анхаар.
22. **Асуулт:** Допингийн хяналтын ажилтан тэмцээний бус үеийн шинжилгээ авахаар гэрт тань ирсэн үед та аяга цай бэлтгэх, эсвэл түүнд үйлчлэхээр өрөөнөөс **ГАНЦААРАА** гарч болно? **Хариулт:** Худал. **Тайлбар:** Шинжилгээг эхлэхээс дуусах бүх хугацаанд допингийн хяналтын ажилтантай цуг байх нь таны өөрийгөө хамгаалж буй хэрэг юм. Хэрэв та өрөөнөөс гарах шаардлагатай бол допингийн хяналтын ажилтанд заавал мэдэгд. Тэр тантай хамт байх болно.
23. **Асуулт:** Хэрэв та долоохон хоногийн өмнө тэмцээний бус үеийн шинжилгээ өгсөн бол дараагийн шинжилгээ өгөх хүртэл заавал хэдэн долоо хоног өнжих шаардлагатай? **Хариулт:** Худал. **Тайлбар:** Таныг дараагийн шинжилгээнд дуудах хүртэл хугацаа хэдэн долоо хоног, хэдэн өдөр, бүр хэдэн цаг ч байж магад. Богино хугацаанд нэгээс илүү шинжилгээг давтан авах нь хууран мэхлэлт давтагдахаас сэргийлэх ач холбогдолтой юм.
24. **Асуулт:** Хэрэв тамирчны эмчийн өгсөн эмнээс хориотой бодис илэрсэн бол энэ нь эмчийн буруу болохоос тамирчны биш? **Хариулт:**Худал. **Тайлбар:** Таны эмч муу зөвлөгөө өгч, буруу эмчилгээ хийснийхээ төлөө шийтгүүлж магад. Гэвч та өөрийнхөө биед юу тариулж,түрхэж, оруулж байгаагаа өөрөө мэдэж байх шаардлагатай. **ХЭРЭГЛЭСЭН ЗҮЙЛИЙНХЭЭ ХАРИУЦЛАГЫГ ТА ӨӨРӨӨ Л ХҮЛЭЭНЭ!**
25. **Асуулт:** Тамирчин ямар ч үед шинжилгээ өгөхөөр сонгогдож болно? **Хариулт:** Үнэн **Тайлбар:** Олон улсын, эсвэл үндэсний хэмжээний тэмцээнд оролцдог тамирчны хувьд допингийн шинжилгээнд зориудаар эсвэл тохиолдлоор орох нь таны үүргийн нэг хэсэг юм. Допингийн шинжилгээнд орох нь цэврээр өрсөлдөж байгаа гэдгээ нотлох боломжийг танд олгоно.
26. **Асуулт:** Хэрэв допингийн хяналтын ажилтан өөрийгөө шинжилгээ авах эрх бүхий гэдгээ нотлох бичиг баримт үзүүлээгүй тохиолдолд тамирчин шинжилгээ өгөхөөс татгалзаж болно? **Хариулт:** Үнэн. **Тайлбар:** Допингийн хяналтын ажилтан нь шинжилгээ авах эрхтэйгээ нотлох бичиг баримтаа заавал үзүүлэх ёстой. Хэрэв тэдэнд ийм бичиг баримт байгаагүй тохиолдолд тамирчин үүнийг мэдэгдэх хуудсан дээр тэмдэглүүлэн, мэдэгдэх хуудасны хуулбарыг авч өөрийн харъяалах холбоонд хурдан мэдэгдэх шаардлагатай.
27. **Асуулт:**Лабораторид дээж хүлээн авсан ажилтан намайг хэн болохыг мэднэ?**Хариулт:**Худал. **Тайлбар:** Шинжилгээний хуудасны лабораторид очдог хувь дээр таны хувийн мэдээлэл тэмдэглэгдэхгүй. Лаборатори зөвхөн спорт, төрөл, тамирчны хүйс, харъяалах холбоо, шинжилгээ авсан өдрийн талаархи мэдээллийг л хүлээн авдаг.

"Please be advised that this information is subject to change at anytime. Always check with your International Federation or National Federation for the most up-to-date anti-doping regulations."

UPDATED January 2009

All rights reserved 2007 WADA

28. **Асуулт :** Тамирчин шинжилгээ өгч дуусахад Допингийн хяналтын ажилтан шинжилгээний хуудасны бүх хувийг хадгалж байгаад тамирчинд зохих хувийг нь дараа өгнө? **Хариулт:**Худал. **Тайлбар:** Допингийн хяналтын ажилтан нь шинжилгээ дуусмагц шинжилгээний хуудас, мэдэгдэх хуудасны зохих хувийг тамирчинд тэр дор нь өгөх ёстой. Тамирчин үүнийг шинжилгээний хариу гарах хүртэл хадгалах үүрэгтэй.
29. **Асуулт:** Тамирчин амралттай байгаа тохиолдолд байршлын тухай дэлгэрэнгүй мэдээллийг зохих газарт өгөх шаардлагагүй. Учир нь тэр амралттай байгаа? **Хариулт: Тайлбар:** Тамирчин амралттай байсан ч байршлын тухай дэлгэрэнгүй мэдээллээ заавал өгөх ёстой. Допингийн Эсрэг Байгууллага шинжилгээ авах шаардлагатай тохиолдолд тамирчны заасан хаягаар очдог.
30. **Асуулт:** Ихэнхи орнуудад анаболик стероидыг спортод бүх цаг үед хэрэглэхийг хориглодог. Анаболик стероидууд дараахи гаж нөлөө үзүүлдэг:
а. Эрэгтэй хүнд хөх ургаж, эмэгтэй хүний хоолой бүдүүрнэ. с. Ширүүн, хэрцгий ааш авиртай болно
b. Элэг, зүрхэнд өөрчлөлт үүснэ. d. Дээрхи бүх шинж тэмдэг гарна
- Хариулт:** d. Дээрхи бүх шинж тэмдэг гарна. **Тайлбар:** Анаболик стероид хэрэглэснээр булчингийн жин нэмэгдэж болох ч дээр дурдсан шинж тэмдгүүд илэрч, та насан туршийн өвчтөн болно. Анаболик стероид хэрэглэх нь зөвхөн өөрийнхөө эрүүл мэндийг эрсдэлд оруулаад зогсохгүй, ямагт цэвэр тамирчин байх ёс суртахуунаа гэж өөрийгөө хуурч байгаа хэрэг.
31. **Асуулт:** ЭЗЧ хөтөлбөр нь тамирчин өвчний хүнд зайлшгүй шаардлагатай тохиолдолд хориотой бодисуудыг эмчилгээнд хэрэглэх боломж олгодог. ЭЗЧ нь зөвхөн тухайн өвчний үед шинж тэмдгийг арилгах, биеийн байдлыг сайжруулахаар орлуулан хэрэглэх эм байхгүй байгаа тохиолдолд л хориотой бодисуудыг хэрэглэх баталгаа болно.
ЭЗЧ гэж юу вэ: а. Эмчилгээний Зорилгоор Чөлөөлөх б. Эмчилгээний Зорилготой Чөлөө
- Хариулт:** а. Эмчилгээний Зорилгоор Чөлөөлөх **Тайлбар:** Олон улсын зэрэглэлийн тамирчин нь тухайн спортын олон улсын холбоонд, үндэсний зэрэглэлийн тамирчин нь Допингийн Эсрэг Байгууллагадаа өргөдөл гаргах үүрэгтэй. Эмчилгээний Зорилгоор Чөлөөлөх батламжид тухайн бодисыг хэрэглэх заалт, тун, хугацаа, давтамж зэргийг тодорхой тусгасан байх шаардлагатай.
32. **Асуулт:** Хүний өсөлтийн гормон (hGH) нь яс,булчин, эдийн ургалтыг түргэсгэдэг. Өсөлтийг гормоныг спортод бүх цаг үеийн турш хэрэглэхийг хориглоно. Өсөлтийн гормоны гаж нөлөө нь:
а: зүрх судасны өвчин үүсгэх с: чихрийн шижин өвчний эрсдэлд хүргэх
b: булчингийн болон хавсарсан өвдөлт, эдийн эмгэг ургалт d: Дээрхи бүх шинжүүд
- Хариулт:** d. Дээрхи бүх шинж **Тайлбар:** Допингийн хяналтанд Хүний өсөлтийн гормоныг (hGH) илрүүлэх шинжилгээ хийж байна.
33. **Асуулт:**Хориотой бодисын жагсаалт нь ямар бодис, аргыг тэмцээний ба тэмцээний бус үед хэрэглэхийг хориглодог болохыг тогтоодог. **Хариулт:** Үнэн. **Тайлбар:** Олон улсын шинжээчийн баг Хориотой бодисын жагсаалтыг жил бүр хянан үзэж, шинэчлэн баталдаг бөгөөд шинэ хувилбар нь 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болдог. Тамирчид уг жагсаалттай холбоотой шинэ мэдээллийг ДДЭА /WADA/-ийн вэб хуудас - www.wada-ama.org -наас авах боломжтой.
34. **Асуулт:** Хэрэв тамирчин хориотой бодис хэрэглэснээ допингийн хяналтын ажилтанд хурдан хэлээгүй бол түүний буруу. Харин хэлж шинжилгээний хуудсан дээр тэмдэглүүлсэн бол ямар ч асуудал үүсэхгүй?
Хариулт: ХУДАЛ. **Тайлбар:** Дэлхийн Допингийн Эсрэг Дүрэмд тамирчны биеээс хориотой бодис илэрсэн тохиолдолд хэрхэн хариуцлага хүлээлгэх тухай нарийвчлан зохицуулагдсан байдаг.
35. **Асуулт:** Далдлагч гэж юу вэ?
а) Хориотой бодис хэрэглэхэд тамирчинд тусалсан хүн

- b) Хориотой бодис хэрэглэснийг далдлах ямар нэг өөр бодис, эсвэл үйл ажиллагаа
- c) Тамирчны бие төлөөлөгч
- d) Допингийн шинжилгээний савыг тагласан таг

Хариулт: b. **Тайлбар:** Допингийн хяналтын үед шээсний болон бусад шинжилгээнд хориотой бодисыг илрүүлэхгүй байх, түүний үйлдлийг нуух зорилготой хэрэглэсэн бодис, үйл ажиллагааг далдлагч гэнэ. Далдлагчдыг тэмцээний болон тэмцээний бус бүх цаг үед хэрэглэхийг хориглоно.

36. **Асуулт:** Шаардлагатай тохиолдолд тамирчин гэмтэлтэй, тэмцээнд оролцохгүй ч байршлын тухай мэдээллээ харъяалах спортын байгууллагад өгнө? **Хариулт:** Үнэн. **Тайлбар:** Тамирчин гэмтэл, өвчний улмаас тэмцээнд оролцохгүй байсан ч тамирчныхаа хувьд байршлын тухай мэдээллээ заавал өгөх үүрэгтэй. Допингийн Эсрэг Байгууллага дурын үед, өгсөн хаягаар тань тантай уулзах болно.
37. **Асуулт:** Допингийн шинжилгээгээр хүний өсөлтийн гормоныг (hGH) тодорхойлж байгаа? **Хариулт:** Үнэн. **Тайлбар:** Хүний өсөлтийн гормоныг 2004 оноос хойш тэмцээний ба тэмцээний бус үеийн шинжилгээгээр цусны дээжинд тодорхойлж байна.
38. **Асуулт:** Допингийн хяналтын цусны шинжилгээ өгвөл миний толгой эргэх, дотор муухайрах шинжүүд илэрнэ. **Хариулт:** Худал. **Тайлбар:** Маш бага хэмжээний цусыг (уруулын будгийн савны хэмжээтэй ойролцоо) тамирчнаас авах бөгөөд ийм хэмжээний цус нь авах нь биед гаж нөлөө үзүүлэхгүй. Сувилагч болон цусны мэргэжилтнүүд шаардлагатай үед танд туслахад бэлэн байх болно.
39. **Асуулт:** Тамирчныг шээс өгөх үед ямар ч хүйсийн ажилтан ажиглаж болно. **Хариулт:** Худал. **Тайлбар:** Тамирчны шээх үйлийг хянах ажилтан нь заавал түүнтэй ижил хүйсийн хүн байх шаардлагатай.
40. **Асуулт:** Тамирчин допингийн хяналтын үйл ажиллагааны аль үе шатанд өөрөө шууд хяналт тавих боломжтой вэ?
a. Шинжилгээ дууссаны дараа дуртай үедээ b. Шинжилгээ өгч байх явцдаа
c. Дэлхийн Допингийн Эсрэг Агентлагт мэдээлэх үед
Хариулт: b. Шинжилгээ өгч байх явцдаа **Тайлбар:** Тамирчин допингийн хяналтын ажилтантай уулзсанаас хойш шинжилгээ дуусах хүртлэх шинжилгээ өгөх бүх үйл явцыг өөрөө шууд хянах боломжтой. Түүнчлэн дээж авах, шинжилгээний хуудас бөглөхтэй холбогдсон нэмэлт мэдээлэл, тодруулга авах эрх тамирчин танд бий.
41. **Асуулт:** Тамирчин тэмцээнд оролцохгүй ч допингийн шинжилгээ өгөхөөр сонгогдож болно. **Хариулт:** Үнэн. **Тайлбар:** Хэрэв таны нэр багийн бүрэлдэхүүнд байгаа л бол тэмцээнд оролцохгүй ч гэсэн таныг допингийн шинжилгээ авахаар сонгож болно.
42. **Асуулт:** Дэлхийн Допингийн Эсрэг Дүрмийн Зорилго юу вэ?
a. Допинг хэрэглэхгүйгээр тэмцээнд шударгаар өрсөлдөх тамирчны үндсэн эрхийг хамгаалах
b. Тамирчны эрүүл мэндийг хамгаалж, шударга өрсөлдөөн, тэгш эрхийг хангах
c. Олон улсын түвшинд допингийн эсрэг хөтөлбөрийн нөлөөг баталгаажуулах
d. Дээрхи бүх зорилго
Хариулт: d. Дээрхи бүх зорилго **Тайлбар:** Дэлхийн Допингийн Эсрэг дүрэм нь спорт дахь допингийн эсрэг дэлхийн хөтөлбөрийн суурь бичиг баримт буюу нэг ёсны допингийн эсрэг үндсэн хууль юм.
43. **Асуулт:** Шинжилгээний эхний хариу сөрөг гарч, асуудлыг цааш хэлэлцэх тохиолдолд тамирчинд дараахи эрх бий:
a. В сорьцийг шинжлүүлэх хүсэлт гаргах
b. В сорьцийг задлах, шинжлэх үйл ажиллагаанд өөрийн биеэр оролцох эсвэл бие төлөөлөгчөө оролцуулах
c. Лабораторийн шинжилгээний шаардлагатай бичиг баримтын хуулбарыг хүсэх
d. Дээрхи бүх эрх

Хариулт:d. Дээрхи бүх эрх **Тайлбар:** Дэлхийн Допингийн Эсрэг Дүрэмд тамирчны эрхийг хүндэтгэж, баталгаажуулсан байдаг.

44. **Асуулт:** Бүх тамирчид допингийн шинжилгээнд сонгодож болох учир шаардлагатай үед байршлын тухай мэдээллээ шинжилгээ авах эрх бүхий байгууллагад өгөх үүрэгтэй. **Харин таны өгсөн мэдээллийг хэн үзэх эрхтэй вэ?**
- Таны мэдээлэл, олон нийт, хэвлэл мэдээлэлд нээлттэй байх учир сонирхсон хүн бүр үзэх боломжтой.
 - Олон нийт, хэвлэл мэдээллийнхэн үзэх эрхгүй, харин допингийн эсрэг байгууллагын ажилтан бүр үзэж болно.
 - Энэ мэдээлэл нь бүх хугацаанд өндөр нууцлалтай байх шаардлагатай тул зөвхөн допингийн эсрэг байгууллагын шинжилгээний төлөвлөлт хариуцсан хүн л мэдэх эрхтэй.
 - Дээрхийн аль нь ч биш

Хариулт: с. **Тайлбар:** Байршлын тухай мэдээлэл бүр маш нууц байх бөгөөд зөвхөн шинжилгээний зорилгоор л ашиглагдана. Зохих хугацаанд ашиглагдаж дууссаны дараа бүх мэдээлэл устгагдана.

45. **Асуулт:** Хориотой бодисын жагсаалт ямар хугацаанд шинэчлэгддэг вэ?

- Сар бүр
- Жил бүр
- Олимпын наадам, паралимпийн наадам бүрийн өмнө
- Жагсаалт огт шинэчлэгддэггүй

Хариулт: b. Жил бүр **Тайлбар:** Олон улсын шинжээчийн баг жил бүр хоритой бодисын жагсаалтыг хянадаг ба шинэчлэгдсэн жагсаалт жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болдог. Тамирчид энэхүү жагсаалт, түүний өөрчлөлт бүрийг Дэлхийн Допингийн Эсрэг Агентлаг /WADA/-ийн вэб хуудас-www.wada-ama.org –оос үзэх боломжтой.

Ps:

Translation of key words

- Mongolian
- Play True quiz
- Question
- Answer
- True
- False
- Welcome!
- What do you know about anti doping?
Test your knowledge here
- Ready?
- Correct
- Wrong
- Next question
- New quiz
- Submit score
- Submit
- Play again

МОНГОЛ ХЭЛ
Допингийн Эсрэг Асуулт Хариулт
Асуулт
Хариулт
Үнэн
Худал
Тавтай морил !
Та допингийн эсрэг сэдвээр юу мэдэх вэ?
Мэдлэгээ шалгана уу
Бэлэн үү?
Зөв
Буруу
Дараагийн асуулт
Шинэ тоглоом
Оноогоо илгээх
Илгээх
Дахин тоглох